



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Амарсанаа
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхтуул
Утас: 261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261740 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Ж.БУЯНБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1207

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг-Шүүх шинжилгээний ерөнхий газар болж, бүсийн шүүх шинжилгээний төвүүдийг байгуулж, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаагаа өргөжүүлж, цахим технологи, инженер техник, хөрөнгийн үнэлгээ болон байгаль орчны хохирлын үнэлгээ, гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох зэрэг шинэ төрлийн шинжилгээнүүд хийж эхэлсэн.

Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч нар 2024 онд улсын хэмжээнд криминалистикийн 7200, инженер техникийн 1078, шүүх, анагаах ухааны 44191, байгалийн ухааны 18202, эдийн засгийн 173, нийт 70844 шинжилгээ хийж дүгнэлт гарган, 32740 удаа хэргийн газарт үзлэгт оролцсон бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шинжилгээний тоо 6578 буюу 10.2 хувь, хэргийн газарт үзлэгт оролцсон тоо 3834 буюу 13.3 хувиар тус тус өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.8 тэрбум төгрөгийн 17 туулах чадвар сайтай, стандартын шаардлага хангасан, тусгай зориулалтын цогцос зөөвөрлөх тээврийн хэрэгсэл, ачааны автомашин, алсын дуудлага, шуурхай бэлэн байдлын автомашиныг тус тус худалдан авч, орон нутгийн Шүүх шинжилгээний нэгжүүдэд хүлээлгэн өгч, автомашины парк шинэчлэлтийн ажлыг хийсэн. Үүний үр дүнд Монгол Улсын 21 аймаг, 330 сумдад шүүх шинжилгээний үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн гүйцэтгэх, иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөл дээшилсэн байна.

Бусад асуудал

Агентлагийн цар хүрээ өргөжин тэлсэнтэй холбоотойгоор БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)”-ийг эхлүүлсэн боловч санхүүжилт зогссоноос төслийн явц удааширч, шинжилгээний лабораториудыг магадлан итгэмжлүүлэхэд үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны нөхцөл шаардлага хангахгүй болсон байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САМБУУНЯМ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,642,809.5	3,458,915.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	131,957.6	320,431.9
33	АВЛАГА	15,492.1	149,500.4
34	УРЬДЧИЛГАА	61,835.9	431,686.5
35	БАРАА МАТЕРИАЛ	1,185,735.0	2,120,956.8
36	НӨӨЦИЙН БАРАА	27,788.9	236,340.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,220,000.0	200,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,789,596.6	35,806,582.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,789,596.6	35,806,582.4
39200	Биет хөрөнгө	25,594,896.8	31,676,184.1
39300	Биет бус хөрөнгө	2,194,699.8	4,130,398.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	31,432,406.1	39,265,498.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,469.2	145,359.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,469.2	145,359.8
41340	Өглөг	149.2	145,359.8
41400	Урьдчилж орсон орлого	21,320.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	31,410,936.9	39,120,138.6
51	Засгийн газрын хувь оролцоо	31,410,936.9	39,120,138.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,181,433.7	6,181,433.7
51200	Хуримтлагдсан үр дүн	20,141,392.1	27,852,535.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,088,111.0	5,086,169.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	31,432,406.1	39,265,498.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	45,023,389.4	50,577,772.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,233,364.9	4,506,050.6
120	Нийтлэг татварын бус орлого	20,091,439.7	4,186,306.7
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	141,925.1	319,744.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,790,024.5	46,071,722.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	24,747,754.8	41,162,155.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,747,754.8	41,162,155.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,266,821.7	37,341,142.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,909,429.3	24,820,410.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	375,207.0	669,025.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	485,055.9	735,277.0
2104	Хангамж, бараа материалын зардал	905,419.7	1,266,431.5
2105	Нормативт зардал	1,279,999.8	2,560,514.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	616,697.4	1,124,375.5
2107	Томилолт, зочны зардал	169,656.6	449,691.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	348,530.8	588,041.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,176,825.3	5,127,375.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,480,933.1	3,821,013.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	20,275,634.6	9,415,617.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,596,547.8	1,706,415.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	15,679,086.7	7,709,201.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,693,087.2	-	15,693,087.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,263.0	-	1,263.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,694,350.2	-	15,694,350.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	37,500.0	-	37,500.0
9	Тайлант үеийн үр дүн	15,679,086.7	-	15,679,086.7
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,410,936.9	-	31,410,936.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,941.4	-	1,941.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,412,878.3	-	31,412,878.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,938.0)	-	(1,938.0)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(3.4)	-	(3.4)
19	Тайлант үеийн үр дүн	7,709,201.7	-	7,709,201.7
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	39,120,138.6	-	39,120,138.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	25,821,152.4	46,359,306.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,821,152.4	46,359,306.9
120	Нийтлэг татварын бус орлого	747,904.4	288,584.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	747,904.4	288,584.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,073,247.9	46,070,722.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,319,889.2	38,712,650.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,319,889.2	38,712,650.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,838,729.9	34,819,154.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,920,604.3	24,819,835.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	373,901.3	669,804.8
2104	Хангамж, бараа материалын зардал	488,036.6	738,044.8
2105	Нормативт зардал	1,017,317.5	1,193,270.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,116,380.3	3,632,665.5
2107	Томилолт, зочны зардал	1,114,534.0	1,496,137.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,920.6	468,269.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	383,454.7	1,336,531.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,580.7	464,594.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,481,159.3	3,893,495.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,501,263.2	7,646,656.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,400,438.2	7,458,182.5
2200	Дотоод эх үүсвэрээр	3,400,438.2	7,458,182.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	3,400,438.2	7,458,182.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(3,400,438.2)	(7,458,182.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,825.0	188,474.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,132.6	131,957.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,107,295,400.00	44,306,434,884.37	44,306,434,884.37	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,888,095,400.00	39,452,001,485.37	39,452,001,485.37	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,703,270,400.00	36,288,601,551.04	36,288,601,551.04	98.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,873,010,900.00	24,767,877,038.65	24,767,877,038.65	99.6
210101	Үндсэн цалин	12,431,796,000.00	12,413,823,072.86	12,413,823,072.86	99.9
210102	Нэмэгдэл	7,623,149,300.00	7,592,199,383.14	7,592,199,383.14	99.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,428,865,900.00	2,404,422,541.85	2,404,422,541.85	99.0
210104	Урамшуулал	2,389,199,700.00	2,357,432,040.80	2,357,432,040.80	98.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	689,995,500.00	668,240,137.72	668,240,137.72	96.8
210201	Тэтгэврийн даатгал	155,138,700.00	143,849,815.44	143,849,815.44	92.7
210202	Тэтгэмжийн даатгал	19,759,200.00	17,279,336.85	17,279,336.85	87.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,011,700.00	10,544,688.74	10,544,688.74	87.8
210204	Ажилгүйдлийн даатгал	8,880,200.00	7,402,160.27	7,402,160.27	83.4
210205	Эрүүл мэндийн даатгал	494,205,700.00	489,164,136.42	489,164,136.42	99.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	744,434,100.00	738,044,808.02	738,044,808.02	99.1
210301	Гэрэл, цахилгаан	212,631,700.00	211,356,697.49	211,356,697.49	99.4
210302	Түлш, халаалт	413,871,000.00	410,669,991.83	410,669,991.83	99.2
210303	Цэвэр, бохир ус	79,006,800.00	77,094,718.70	77,094,718.70	97.6
210304	Байрны түрээс	38,924,600.00	38,923,400.00	38,923,400.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,186,821,000.00	1,180,839,897.66	1,180,839,897.66	99.5
210401	Бичиг хэрэг	275,261,600.00	274,697,575.50	274,697,575.50	99.8
210402	Тээвэр, шатахуун	470,516,800.00	465,783,242.00	465,783,242.00	99.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112,217,800.00	111,606,183.16	111,606,183.16	99.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,064,700.00	44,002,700.00	44,002,700.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	284,760,100.00	284,750,197.00	284,750,197.00	100.0
2105	Нормативт зардал	3,859,757,600.00	3,602,344,622.00	3,602,344,622.00	93.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,012,787,800.00	1,839,830,117.00	1,839,830,117.00	91.4
210502	Хоол, хүнс	167,614,700.00	167,533,640.00	167,533,640.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,679,355,100.00	1,594,980,865.00	1,594,980,865.00	95.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,739,519,800.00	2,739,336,727.00	2,739,336,727.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,521,111,000.00	1,521,055,321.00	1,521,055,321.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	370,516,400.00	353,876,286.00	370,421,286.00	95.5
210604	Урсгал засвар	847,892,400.00	864,405,120.00	847,860,120.00	101.9
2107	Томилолт, зочны зардал	480,452,400.00	468,269,218.93	468,269,218.93	97.5
210701	Гадаад албан томилолт	145,157,000.00	144,490,952.00	144,490,952.00	99.5
210702	Дотоод албан томилолт	320,295,400.00	308,778,374.93	308,778,374.93	96.4
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,000,000.00	14,999,892.00	14,999,892.00	100.0

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,046,303,200.00	2,040,695,429.86	2,040,695,429.86	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,619,223,400.00	1,617,796,521.00	1,617,796,521.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,929,000.00	4,329,000.00	4,329,000.00	87.8
210803	Даатгалын үйлчилгээ	65,911,000.00	65,377,378.00	65,377,378.00	99.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,242,400.00	4,801,197.00	4,801,197.00	76.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,667,900.00	2,033,000.00	2,033,000.00	76.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	248,493,700.00	248,493,391.86	248,493,391.86	100.0
210807	Газрын төлбөр	6,342,400.00	5,374,032.00	5,374,032.00	84.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	92,493,400.00	92,490,910.00	92,490,910.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,975,900.00	82,953,671.20	82,953,671.20	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,975,900.00	82,953,671.20	82,953,671.20	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,184,825,000.00	3,163,399,934.33	3,163,399,934.33	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,184,825,000.00	3,163,399,934.33	3,163,399,934.33	99.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,241,310,700.00	2,219,985,739.33	2,219,985,739.33	99.0
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	76,100.00	-	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	943,438,200.00	943,414,195.00	943,414,195.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,219,200,000.00	4,854,433,399.00	4,854,433,399.00	93.0
220001	Барилга байгууламж	469,200,000.00	469,200,000.00	469,200,000.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	4,750,000,000.00	4,385,233,399.00	4,385,233,399.00	92.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,107,295,400.00	44,306,434,884.37	44,544,864,717.68	98.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,107,295,400.00	44,305,137,284.37	44,543,567,117.68	98.2
310001	Улсын төсвөөс санхүүжих	45,107,295,400.00	44,305,137,284.37	44,543,567,117.68	98.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,297,600.00	1,297,600.00	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,297,600.00	1,297,600.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
610001	Төсвийн байгууллага	23	23	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	743	703	-	94.6
620001	Удирдах ажилтан	23	23	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	703	663	-	94.3
620003	Үйлчлэх ажилтан	17	17	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	743	703	-	94.6
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	721	681	-	94.5

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	7	7	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,328,193,469.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,269,028,981.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,068,893,874.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		51,958,720.03
210104	Урамшуулал		51,958,720.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,564,630.55
210201	Тэтгэврийн даатгал		423,455.09
210202	Тэтгэмжийн даатгал		49,818.36
210203	ҮОМШӨ-ний даатгал		29,163.18
210204	Ажилгүйдлийн даатгал		20,654.18
210205	Эрүүл мэндийн даатгал		1,041,539.74
2104	Хангамж, бараа материалын зардал		11,470,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		11,470,000.00
2105	Нормативт зардал		29,893,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		27,325,600.00
210502	Хоол, хүнс		567,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		583,189,605.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		540,459,605.00
210602	Тавилга		6,185,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		16,545,000.00
210604	Урсгал засвар		20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,632,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		13,632,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		377,185,619.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		122,170,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		255,015,239.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		200,135,107.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		55,341,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		55,341,900.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		144,793,207.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		144,793,207.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		59,164,488.00
2200	Дотоод эх үүсвэрээр		59,164,488.00
222001	Тоног төхөөрөмж		54,164,488.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,328,193,469.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,328,193,469.58
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		795,311,530.58
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		461,973,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		70,908,939.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн харьяа 23 төсвийн байгууллагаас 12 байгууллагыг түүвэрт хамруулж, 11 байгууллагад дүгнэлт гаргасан.

Аудитад хамрагдсан 12 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 245.7 сая төгрөгийн 16 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 60.5 сая төгрөгийн 8 зөрчил² илэрснээс 19.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 40.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 60.5 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 19.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 40.9 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 60.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 368.2 сая төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт 1. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан шатахууны худалдан авалтаас гадна Петростар ХХК-тай 19.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 19.6 сая төгрөгийн шатахуун худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т “төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг батлах”, 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд баталснаас илүү дүнгээр шууд гэрээ байгуулж, бараа худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт 2. Тайлант оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 19.6 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 40.9 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 260.6 сая төгрөгийн 1 албан шаардлага, 82.5 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн. Нийт зөрчлийн дүн өмнөх оноос албан шаардлага 98.8 сая төгрөг, зөвлөмж 136.0 сая төгрөг нийт 234.8 сая төгрөгөөр буурсан боловч зарим зөрчлүүд давтан гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүх шинжилгээний ерөнхий газрын харьяа байгууллагуудын дотоод хяналт, сахилга хариуцлагыг илүү сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт 1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 27 нэр төрлийн 13.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээ хийгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг цаг тухай бүр дахин үнэлгээ хийлгэж, үнийн шинэчлэн тогтоож ажиллахыг зөвлөж байна.

2. Урьдчилж гарсан зардал данстай холбоотой

Илрүүлэлт 2. БНСУ-ын сургалтын хугацаа хойшилсон байхад 15.0 сая төгрөг, 2025 онд Япон улсад хийх ажлын айлчлалын 10.5 сая төгрөг, нийт 25.5 сая төгрөгийг гадаад томилолтод зарцуулж, жилийн эцэст урьдчилж гарсан зардалд тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Санхүү, төсвийг зохистой удирдах, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах”, 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Баталсан төсвийг үр ашигтай зарцуулж, албан томилолтоор ажилласан тухай бүрд зардлыг олгож, урьдчилан зарцуулж, авлага үүсгэхгүй ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хэрэгжилтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 245.7 сая төгрөгийн 16 алдаа³ илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/Мянган төгрөг/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дорноговь аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	5	203,377.4			5	203,377.4	5	203,377.4	0	-	0	-
Дорнод аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	4	11,693.5			4	11,693.5	4	11,693.5				
Өмнөговь аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	2	312.0			2	312.0	2	312.0				
Төв аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	11,570.8	1	11,570.8			1	11,570.8				
Хэнтий аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	414.6			1	414.6	1	414.6				
Говьсүмбэр аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	3	18,320.7			3	18,320.7	3	18,320.7				
Нийт	16	245,688.2	1	11,570.8	15	234,117.4	16	245,688.2	-	-	-	-

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4.2. Аудитаар нийт 60.5 сая төгрөгийн 8 зөрчил⁴ илэрснээс 19.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 40.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төв аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	96.0	0	-	0	-	1	96.0	-	-	-	-
Орхон аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	2	242.1	0	-	0	-	2	242.1	-	-	-	-
Говьсүмбэр аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	1,873.5	0	-	0	-	1	1,873.5	-	-	-	-
Шүүх шинжилгээний ерөнхий газар /аппарат/	3	58,292.5	0	-	1	19,636.2	2	38,656.3	-	-	-	-
Шүүх шинжилгээний ерөнхий газар	1	-	0	-	1	-	-	-	-	-	-	-
Нийт	8	60,504.1	-	-	2	19,636.2	6	40,867.9	-	-	-	-

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх, тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 343,061.8 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 260,573.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 82,488.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шүүх шинжилгээний ерөнхий газар/аппарат/	1	-					1	-
Өмнөговь аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	-					1	-
Баянхонгор аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	260,573.8			1	260,573.8		
Дүн	3	260,573.8			1	260,573.8	2	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийслэлийн шүүх шинжилгээний газар	1	82,488.0					1	82,488.0
Дүн	1	82,488.0					1	82,488.0
Нийт дүн	4	343,061.8	-	-	1	260,573.8	3	82,488.0